



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дөргөн сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/152/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Б.Бадамцэцэг Утас:99062042 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

Ховд.Од.25 № 170

танай _____ -ны № _____ -т

ДӨРГӨН СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ДАВААСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөргөн сумын цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд хүүхэд өдрийн төлөвлөгөө 44179 өдрөөр батлагдаж гүйцэтгэлээр 19902 хүүхэд буюу 45.0 хувьтай, улсын төсвөөс 910,015.4 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч гүйцэтгэлийн үнэлгээнд 3 дугаар түвшинд 1 багш, 4 дүгээр түвшинд 1 багш, 5 дугаар түвшинд 7 багш үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

8420050395
A4-Тоот-2026

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 83.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>224,969,591.18</u>	<u>137,325,237.32</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	117,039,220.38	15,988,356.52
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	117,039,220.38	15,988,356.52
3122	Гадаад валют	117,039,220.38	15,988,356.52
31221	Төрийн сангийн харилцах	117,039,220.38	15,988,356.52
33	АВЛАГА	-	10
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	10
35	БАРАА МАТЕРИАЛ	107,930,370.80	121,336,870.80
351	Түүхий эд материал	37,128,834.30	37,128,834.30
35110	Тусгай зориулалттай материал	36,428,834.30	36,428,834.30
35130	Эм боох материал	700,000.00	700,000.00
354	Хангамжийн материал	70,801,536.50	84,208,036.50
35410	Бичиг хэргийн материал	1,724,000.00	3,103,500.00
35420	Аж ахуйн материал	31,055,475.00	36,958,075.00
35440	Түлш, шатах тослох материал	1,240,000.00	-
35450	Барилгын засварын материал	-	83,600.00
35460	Хүнсний материал	1,797,155.00	5,802,955.00
35470	Бусад хангамжийн материал	34,984,906.50	38,259,906.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>500,581,751.61</u>	<u>473,569,193.69</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	500,581,751.61	473,569,193.69
392	Биет хөрөнгө	486,303,151.61	459,440,593.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	532,249,013.44	532,249,013.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-104,427,608.63	-123,629,521.67
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	66,161,432.00	56,361,696.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46,049,213.59	-41,793,925.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,561,540.48	74,617,122.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	-52,092,012.09	-40,054,090.97
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	900,000.00	900,000.00
39217	Ном	-	790,300.00
393	Биет бус хөрөнгө	14,278,600.00	14,128,600.00
39301	Програм хангамж	1,182,000.00	1,182,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-882,000.00	-1,032,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,978,600.00	13,978,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>725,551,342.79</u>	<u>610,894,431.01</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>725,551,342.79</u>	<u>610,894,431.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	725,551,342.79	610,894,431.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	542,229,470.00	542,229,470.00
51101	Өмч: - төрийн	542,229,470.00	542,229,470.00
512	Хуримтлагдсан үр дүн	149,272,506.08	34,615,594.30
51210	Өмнөх үеийн үр дүн	149,272,506.08	149,272,506.08
51220	Тайлант үеийн үр дүн	-	-114,656,911.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,049,366.71	34,049,366.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>725,551,342.79</u>	<u>610,894,431.01</u>

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН (Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,014,224,550.00	959,770,054.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,914,450.00	3,175,454.00
120	Нийтлэг татварын бус орлого	58,914,450.00	3,175,454.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	58,914,450.00	3,175,454.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,950,800.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	41,963,650.00	3,175,454.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	955,310,100.00	956,594,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	908,410,000.00	910,015,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	908,410,000.00	910,015,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,900,100.00	46,579,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,900,100.00	46,579,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	923,351,194.71	1,074,426,965.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	923,351,194.71	1,074,426,965.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	912,914,981.04	1,072,865,573.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	654,097,126.93	812,029,369.46
210101	Үндсэн цалин	414,269,179.66	516,299,922.97
210102	Нэмэгдэл	199,685,497.27	253,939,106.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	355,000.00
210104	Урамшуулал	40,142,450.00	41,435,340.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,342,408.36	103,152,623.04
210201	Тэтгэврийн даатгал	56,848,607.01	70,481,096.57
210202	Тэтгэмжийн даатгал	6,611,083.82	8,173,657.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,442,285.95	4,216,653.24
210204	Ажилгүйдлийн даатгал	3,258,908.83	4,008,948.67
210205	Эрүүл мэндийн даатгал	13,181,522.75	16,272,267.23
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,200,586.33	44,279,708.00
210301	Гэрэл, цахилгаан	4,176,186.33	6,086,108.00
210302	Түлш, халаалт	37,024,400.00	37,001,600.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,192,000.00
2105	Нормативт зардал	65,383,200.00	60,876,000.00
210502	Хоол, хүнс	65,383,200.00	60,876,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,510,000.00	-
210604	Урсгал засвар	1,510,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,265,000.00	1,852,961.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,071,500.00	-

**Дөргөн сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,193,500.00	1,852,961.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,116,659.42	50,674,911.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,658,085.00	15,022,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,753,700.00	4,673,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,704,874.42	30,978,311.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,436,213.67	1,561,392.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,176,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,176,700.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,259,513.67	1,561,392.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,259,513.67	1,561,392.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>90,873,355.29</u>	<u>-114,656,911.78</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>90,873,355.29</u>	<u>-114,656,911.78</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>972,260,900.00</u>	<u>956,594,600.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,950,800.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	16,950,800.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,950,800.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,950,800.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	955,310,100.00	956,594,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	908,410,000.00	910,015,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	908,410,000.00	910,015,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,900,100.00	46,579,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,900,100.00	46,579,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>898,926,640.29</u>	<u>1,057,645,463.86</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	898,926,640.29	1,057,645,463.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	888,490,426.62	1,056,084,071.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	654,321,233.52	813,423,402.50
210101	Үндсэн цалин	414,614,008.28	498,602,802.87
210102	Нэмэгдэл	198,457,873.14	270,896,174.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	355,000.00
210104	Урамшуулал	41,249,352.10	43,569,425.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,118,301.77	101,758,600.00
210201	Тэтгэврийн даатгал	56,520,469.21	69,036,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,649,508.15	8,180,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,324,704.06	4,090,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,324,704.06	4,090,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,298,916.29	16,361,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,440,586.33	43,039,708.00

**Дөргөн сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210301	Гэрэл, цахилгаан	4,176,186.33	6,086,108.00
210302	Түлш, халаалт	38,264,400.00	35,761,600.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,192,000.00
2105	Нормативт зардал	57,634,720.00	64,881,800.00
210502	Хоол, хүнс	57,634,720.00	64,881,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	1,978,100.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,978,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,554,800.00	3,312,961.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,071,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,483,300.00	3,312,961.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,220,785.00	27,689,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,040,085.00	20,819,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,180,700.00	6,870,450.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,436,213.67	1,561,392.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,176,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,176,700.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,259,513.67	1,561,392.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,259,513.67	1,561,392.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>73,334,259.71</u>	<u>-101,050,863.86</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	73,334,259.71	-101,050,863.86
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	43704960.67	117,039,220.38
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	117,039,220.38	15,988,356.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	542,229,470.00	34,049,366.71	58,399,150.79	634,677,987.50
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	542,229,470.00	34,049,366.71	58,399,150.79	634,677,987.50
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	90,873,355.29	90,873,355.29
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	542,229,470.00	34,049,366.71	149,272,506.08	725,551,342.79
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	542,229,470.00	34,049,366.71	149,272,506.08	725,551,342.79
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	542,229,470.00	34,049,366.71	149,272,506.08	725,551,342.79
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(114,656,911.78)	(114,656,911.78)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	542,229,470.00	34,049,366.71	34,615,594.30	610,894,431.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,073,633,820.38	1,057,645,463.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,073,633,820.38	1,057,645,463.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,073,633,820.38	1,056,084,071.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	822,834,420.38	813,423,402.50
210101	Үндсэн цалин	517,791,020.38	498,602,802.87
210102	Нэмэгдэл	279,473,900.00	270,896,174.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт		355,000.00
210104	Урамшуулал	25,569,500.00	43,569,425.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,758,600.00	101,758,600.00
210201	Тэтгэврийн даатгал	69,036,000.00	69,036,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,180,700.00	8,180,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,090,300.00	4,090,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,090,300.00	4,090,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,361,300.00	16,361,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,547,200.00	43,039,708.00
210301	Гэрэл, цахилгаан	7,585,600.00	6,086,108.00
210302	Түлш, халаалт	35,761,600.00	35,761,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,192,000.00
2105	Нормативт зардал	70,296,100.00	64,881,800.00
210502	Хоол, хүнс	70,296,100.00	64,881,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,032,000.00	1,978,100.00
210604	Урсгал засвар	2,032,000.00	1,978,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,015,600.00	3,312,961.36
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,015,600.00	3,312,961.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,149,900.00	27,689,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,279,300.00	20,819,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,870,600.00	6,870,450.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,561,392.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,561,392.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		1,561,392.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,073,633,820.38	956,594,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	910,015,400.00	910,015,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	910,015,400.00	910,015,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,579,200.00	46,579,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	46,579,200.00	46,579,200.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		117,039,220.38
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		15,988,356.52

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,269.1 мянган төгрөгийн алдаа илэрснээс санхүүгийн тайланд алдаатай илэрхийлсэн 27.3 мянган төгрөгийн гүйлгээг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийж зөрчлийг арилгуулсан. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн элэгдэл зөрүүтэй бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", нийт 27.3 мянган төгрөгийг

залруулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт 1,269.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил 1,241.7 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1,241.7 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс, 1,241.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Цалин урамшуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 08 дугаар сарын 25 өдрийн Б/22 тоот тушаалаар санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан гэх үндэслэлээр 1,241,744 (Нэг сая хоёр зуун дөчин нэгэн мянган долоон зуун дөчин дөрвөн) төгрөгийн балансын урамшуулал гэсэн утгаар давхардуулан олгож буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Хүүхдийн ирцийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Боловсрол мэдээллийн esis.edu.mn системд илгээсэн 2025 оны 03-12 саруудын хүүхдийн ирцийн тоо мэдээг байгууллагын багш нарын өдөр тутамд хөтөлдөг "бүлгийн ирц бүртгэл"-ийн журналын тоотой тулгахад 2636 хүүхэд өдрөөр зөрүүтэй бүртгэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; " 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх; ", БШУЯ-ны 2020 оны 3/1557 дугаар албан бчиг "Боловсролын салбарын удирдлага мэдээллийн систем"-ийн www.esis.edu.mn цахим системийг ашиглан бүртгэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Боловсролын мэдээллийн esis.edu.mn цахим бүртгэлд тухай бүрд мэдээллийг үнэн зөв оруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-г заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Дөргөн сумын хүүхдийн Цэцэрлэг	Үр дүн болон элэгдлийг санхүүгийн тайланд зөрүүтэй илэрхийлэгдсэн	2	27.3	-	-	2	27,3	2	27,3	-	-	-	

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хуульд	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр дүнгийн урамшуулал илүү олгосон	1	1,241.7	1	1,241.7					-	-	-	-
Боловсрол мэдээллийн esis.edu.mn систем дэх ирцийн бүртгэл багш нарын өдөр тутамд хөтөлдөг "бүлгийн ирц бүртгэл"-ийн журнал дахь хүүхдийн тоо 6401 хүүхэд өдрөөр зөрүүтэй бүртгэсэн	1						1	0				
Нийт дүн	2	1,241.7	1	1,241.7			1	0				

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			